



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/438

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны Ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1, 49 дүгээр зүйлийн 49.3, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.1, 35.3.3, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол дүүргийн 12 дугаар хорооны нутаг худалдаа, үйлчилгээний зориулалттай 164 м2 газар эзэмшүүлсэн тус Дүүргийн Засаг даргын 2019 оны А/477 дугаар захирамжийн иргэн Оросоогийн Гончигсүрэн (МЭ82111273)-д холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхтөр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР